



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 5/922

Улаанбаатар хот


Г.Шинэбаярт буцалтгүй тусламж
олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Шивээхүрэн дэх гаалийн газарт үйлчлэгчээр ажиллаж байгаад тус гаалийн газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн Б/44 дүгээр тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарч, ажлаас чөлөөлөгдсөн Гэндэнгийн Шинэбаярт төрийн алба хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 6 776 260 / зургаан сая долоон зуун далан зургаан мянга хоёр зуун жаран/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/ -т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ

1439501 3017